

Монголын Материал Судлал Гагнуурын Нийгэмлэгийн

2017 онд хийсэн ажлын тайлан

2018 оны 02-р сарын 08.

Нэг. Монголын Материал Судлал Гагнуурын Нийгэмлэгээс тайлангийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар

1. ММСГН ээс 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ,хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаа.

2. Нийгэмлэгийн www.mmsws.mn вебсайтыг байнга ажиллуулж, мэдээллүүдийг шинэчилж ажиллаж ирлээ.

3. Нийгэмлэгийн үндсэн зорилт, үйл ажиллагаа болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүст сурталчлах, танилцуулах ажлыг байнга зохион байгуулж ажиллав.

4. ММСГН т хандаж ажил төрлийн холбоо тогтоох гагнуурын ИТА ыг сургалтад хамруулах гагнуурчдыг аттестатчилалд оруулах гагнуур металл судлалын чиглэлээр зөвлөгөө авах гагнуурын ажлын чанар шалгуулах гагнуурчин бэлдэх талаар санал тавьсан хүмүүстэй уулзах аль болох тус дэм болох чиглэлийг барьж ажиллаж байна

5. Мэргэжлийн гагнуурчдын улсын аваргын тэмцээний үеэр (2017 оны 11-р сарын 25) „Нийгэмлэгийн үүрэг зорилго цаашдын зорилго чиглэл”-ийн талаар гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн, „Дэлхийн үр чадварын тэмцээнүүдэд гагнуурын чиглэлээр хэрхэн оролцож буй” талаар Нийгэмлэгийн гишүүн эксперт С.Батсайхан нар ЭХЯ болон гишүүн байгууллагуудын зарим удирдлага, инженер, гагнуурчдад танилцуулга- презентаци бэлдэж тавив.

6. 2017 оны 12-р сарын 16- 17-нд Тэрэлжийн Red Rock- д ХНХЯам, ГОУХАН /GIZ/ хамтран зохион байгуулсан Дэлхийн үр чадварын тэмцээнд Монгол улсын баг хэрхэн оролцсон цаашид авах арга хэмжээний талаар хийсэн уулзалт семинарт ММСГН- ийн Удирдах Зөвлөлийн дарга Ж.Түмэн Аюуш, гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн, нийгэмлэгийн гишүүн эксперт С.Батсайхан нар оролцлоо.

Уулзалтын үеэр Дэлхийн үр чадварын тамцээнд амжилт гаргахын тулд дотоодын сорил тэмцээнүүдийг эрт хийх, шалгарсан 2 оролцогчийг БНХАУ, ОХУ-д болдог олон улсын тэмцээнүүдэд 1-2 удаа оролцуулах, бэлтгэлийг урт хугацаанд хийх зэрэг саналууд тавьж дэмжигдсэн.

7. Эрдэс Баялаг Эрчим Хүчний сайдыэ 2010 оны 01-р сарын 25-ны өдрийн 21 тоот тушаалаар батлагдсан „Гагнуурчид болон гагнуурын инженер техникийн ажилтныг мэргэшүүлж эрх олгох дүрэм”- ийн дагуу Оюу толгой ХХК, Хасумегаватт ХХК,EES ХХК, Зэт Эм И ХХК ,MCS ХХК, Барилга ХХК, Алтимет ХХК, Батс Өргөө ХХК, ДСМ ХХК,Эрдэнэт- OTK, Эм Жи Эл Би ХХК, Major Drilling ХХК зэрэг 26 байгууллагын 151, хувиараа 34 мэргэшсэн гагнуурчин болон Герман Монголын Мэргэжил

Сургалт Үйлдвэрлэлийн Төв ийн сургалтад хамрагдсан 85, нийт 270 гагнуурчдаас мэргэжлийн шалгalt авч гэрчилгээ олгосн байна

8. Гагнуурын үйлдвэрлэл ажил үйлчилгээтэй холбоотой стандартыг нэвтрүүлэх боловсронгуй болгох ажлын хүрээнд ММСГН ээс боловсруулж батлуулсан 17 стандартыг байгууллага, ААН, компанид өгч мөрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулаа.

9. АНУ ын Чикаго хотод 2017 оны 11-р сард зохион байгулагдсан ОУ-ын гагнуурын Үзэсгэлэнд Зэт Эм И ХХК, Оч шим ХХК ын 6 хүнийг оролцуулах ажлыг зуучлан зохион байгуулав.

2017 оны 6-р сард Шанхайд болсон гагнуурын үзэсгэлэнд ДЦС- 2, 3, 4-ын инженерүүд ,гагнуурчдыг оролцуулах ажлыг зохион байгуулаа.

Мөн оны 9-р сард ХБНГУ-ын Дюссeldorf т болсон олон улсын гагнуурын техник, технологийн үзэсгэлэнд Гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн, Удирдах зөвлөлийн гишүүн Б.Зулбаяр, гишүүн Баяр нар оролцсон.

Үзэсгэлэнгийн үеэр ХБНГУ-ын Халлигийн Гагнуурын Холбооны Нийгэмлэг, Ханноверын Гагнуурын Нийгэмлэгийн удирдлагатай уулзаж, хамтын ажиллагааны талаар санал бодлоо хуваалцаж, хамтран ажиллах чиглэлүүдээ тохирсон.

10. БНХАУ-ын Шанхай хотод 2017 оны 6-р сард зохион байгуулагдсан олон улсын гагнуурчдын үр чадварын „ ARC CUP- 2017” тэмцээнд Монголын гагнуурчдын багийг оролцуулах ажлыг зохион байгуулаа. Энэ тэмцээнд БНХАУ, ОХУ, Украян, Вьетнам, Серб, ΘΑΒΗΥ зэрэг 14 орны 248 гагнуурчид оролцсон. ММСГН 2015 оны мэргэжлийн гагнуурчдын улсын аваргын тэмцээнд амжилт гарган эхний байр эзэлсэн төрийн болон хувийн хэвшлийн 7 гагнуурчныг 4 төрлөөр бэлдэж тэмцээнд оролцуулав. Тэмцээнээс хагас автомат төрөлд М.Ганхуяг /ДЦС- 3 ТӨХК/,

Б.Баттулга / СММ ХХК/ нар мөнгөн медаль, Хийцийн төрөлд Л.Анхбаяр /Хасумегаватт ХХК/, аргон гагнуурт Ч.Агаандэмбэрэл / ДЦС- 4 ТӨХК/ нар хүрэл медал, оюутны ангилалд 17 настай Д.Нямрагчаа / ГММСҮТ/ 3-р байр эзлэн, багийн дүнгээр 2-р байранд орж, 2014, 2016 оны Бээжингийн тэмцээний амжилтаа бататгалаа.

11. Бээжин хотод 2017 оны 11-р сарын сүүлээр болсон Бүх Хятадын Үйлдвэрчний Хорооны зохион байгуулсан „Нэг зам- Нэг бүс” хөтөлбөрийн хүрээнд болсон туршлага солилцох арга хэмжээ болон гагнуурын үр чадварын тэмцээнд ММСГН зохион байгуулж 1 инженер 5 гагнуурчин оролцуулав. Энэ үеэр үзүүлэн сургалт, гагнуурын тэмцээн, гагнуурын бүрэн автоматжлагдсан үйлдвэр үзэх, Тянжин хот, Цагаан хэрэм үзэх зэрэг ажлууд зохион байгуулсан байна.

Энэ арга хэмжээнд Хятад, Беларус, Казахстан, Пакистан, Энэтхэг ,Армени, Афганистан, Узбекистан, Киргизстан, Непал зэрэг орнууд оролцсон. ДЦС- 3 ТӨХК,ДЦС- 4 ТӨХК , Хасумегаватт ХХК, Linux ХХК, ZMEngineering ХХК- уудын төлөөлөл оролцож, нийгэмлэгийн гишүүн, инженер О.Мөнхтөгс ахалж ажиллав . Гагнуурын тэмцээнээс цахилгаан гагнуурын төрөлд Н.Ганцроож / ДЦС- 4 ТӨХК/ алт, аргон гагнуурын төрөлд Б.Баянмөнх /Хасумегаватт/ мөнгө, хагас автомат төрөлд Т.Баттогтох /ZME/

Нямрагчаа /ГММСҮТ/ нар мөнгөн медаль хүртсэн. Энэ арга хэмжээг ММСГН санаачилж оролцсон байгууллага, хувь хүнээс мөнгө гаргуулалгүй маш үр дүнтэй зохион байгуулав.

12. Монголын мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдэд гагнуурын мэргэжлээр суралцаагсын дунд зохион байгуулсан „Монгол ур чадвар” тэмцээний эхний шатнаас шалгарсан 6 суралцагч оролцсон 2 дахь шатны тэмцээнийг ХНХЯам, ГОУХАН- тэй хамтран 2017 оны 1-р сард явуулж, Д.Нямрагчаа /ГММСҮТ/, ЖЖанлавОйдов/ ТТДС/ нар шалгарч үлдэв.

Хоёрдугаар шатны тэмцээнийг 2017 оны 5-р сард зохион байгуулж, ЖЖанлавОйдов /ТТДС/ шалгарч, Абу-Дабид болох дэлхийн ур чадварын тэмцээнд оролцох эрх авсан. Тэмцээнүүдийн ажлын даалгавар бэлдэх, удирдамж гаргах, бэлтгэл ажлууд хангах, материал сорьц бэлдэх зэрэг бүх ажлыг нийгэмлэг зохион байгуулав. Энэ тэмцээний эхний 6 байр эзэлсэн суралцаагсыг ХНХЯамтай хамтран тус бүрийг 450000 төгрөгийн солонгос гагнуурын аппаратаар урамшуулах ажлыг зохион байгуулаа.

13., „Монгол ур чадвар” тэмцээний эхний 2 байр эзэлсэн гагнуурчдыг 2017 оны 3-р сараас эхлэн Оюутолгой ХХК-д тэдний зардлаар бэлдэх ажлыг ХНХЯамтай зохион байгуулж, Нийгэмлэгийн гишүүн С.Батсайхан /ДЦС- 4 ТӨХК/ газар дээр нь очиж хяналт тавих, заавар зөвлөгөө өгөх зэргээр туслалцаа үзүүлэв.

ММСГН-ээс Абу-Дабигийн дэлхийн ур чадварын тэмцээний гагнуурын экспертийн сонгон шалгаруулалтанд С.Батсайханыг албан ёсоор дэвшүүлж тэнцсэн.

13. АНЭмират улсын АбуДаби хотод 2017 оны 10-р сарын 15-18 нд болсон Дэлхийн ур чадварын тэмцээнд гагнуурын төрлөөр Ж.Жанлав-Ойдов /ТТДС/ оролцож, 700 оноогоор шилдэг оролцогчийн „Medalion for Excellence” мөн үндэсний шилдгийн „ Best of Nation” шагнал авч сайхан амжилт гаргав. Энэ тэмцээний экспертээр С.Батсайхан 2 дахь удаагаа амжилттай оролцлоо.

14. ММСГН монголын мэргэжлийн гагнуурчдын дунд 2 жил тутам зохион байгуулдаг улсын аваргын 4 дэх удаагийн тэмцээнийг 2017 оны 11-р сарын 20-25 ны өдрүүдэд ГММСҮТөв дээр Эрчим Хүчиний Хөгжлийн Төв, Хасумегаватт ХХК-тай хамтран зохион байгуулсан. Уг тэмцээнд эрчим хүч, уул уурхай, төмөр зам, МИАТ, МСҮТөвүүд зэрэг хот хөдөөгийн 42 байгууллагын 140 гаруй мэргэжлийн гагнуурчид гагнуурын 4 төрлөөр оролцов. Тэмцээний эхний байруудад шалгарсан 35 нас хүрээгүй 9 гагнуурчинд 2018 оны 6-р сард Бээжинд болох олон улсын мэргэжлийн гагнуурчдын „ARC CUP-2018 ” тэмцээнд оролцох эрхийн бичиг олголоо.

Цахилгаан гагнуурын төрөлд 42 байгууллагын 78 гагнуурчин оролцсоноос:

Б.Эрдэнэбаяр /ДЦС 3 ТӨХК/ 1-р байр, Х.Бямбажав /Эм Си Эс ХХК/ 2-р байр, Т.Сарантөгс /ДЦС- 3 ТӨХК/ 3-р байр.

Хагас автомат төрөлд 31 байгууллагын 43 гагнуурчин өрсөлдөж М.Ганхуяг /ДЦС-3 ТӨХК/ 1-р байр, Ж.Мягмарсүрэн /ДЦС-3 ТӨХК/ 2-р байр, Д.Нямрагчаа /ГММСҮТ/ 3-р байр.

Аргон гагнуурт 19 байгууллагын 27 гагнуурчин оролцож Ч.Агаандэмбэрэл /ДЦС -4 ТӨХК/ 1-р байр, Н.Энхбат /NBIK ХХК/ 2-р байр, С.Тэнүүн /Эм Эс Эф ХХК/ 3-р байр эзлэв.

Хийн гагнуурын төрөлд 5 байгууллагын 7 гагнуурчин оролцож 1,2,3-р байр эзлэх гагнуурчин гараагүй. Тэмцээнд 1-р байр эзэлсэн гагнуурчинд 700000 төг, 2-р байр 500000 төг, 3-р байр 300000 төг, өргөмжлөлийн хамт өглөө. Харин хийн гагнуурын төрөлд Э.Батсүх / ДЦС- 4 ТӨХК/, Г.Отгонбаяр /Багануур ХК/ нарыг тусгай байр эзлүүлж, тус бүр 100000 төгөөр урамшууллаа.

15. Тэмцээний үеэр гагнуурын техник хэрэгсэл, эд материалын үзэсгэлэн худалдаа гаргах, гагнуурын үйл ажиллагааны чиглэлээр танилцуулга, хурал хийх зэрэг арга хэмжээг зохион байгуулав.

ММСГН нь байгуулагдсанаасаа хойш мэргэжлийн гагнуурчдын дунд болон мэргэжлийн боловсролын сургалтын төвүүдэд суралцагсын хооронд гагнуурын үр чадварын тэмцээнүүдийг улсын хэмжээнд нийтдээ 7 удаа зохион байгуулж, олон үлсын тэмцээнд 5 удаа оролцуулсан байна. Энэ ажил гагнуурын мэргэжлийг сурталчлах, туршлага солилцох, шинэ техник технологитой танилцах, байгууллага, сургууль, гагнуурчдын дунд өрсөлдөөнийг бий болгож улмаар тэдний үр чадварыг дээшлүүлэхэд томоохон түлхэц болсон.

16. Нийгэмлэг Азийн Гагнуурын Холбооны үйл ажиллагаанд байнга оролцож жилийн хураамжкаа төлж ирсэн.

Азийн Гагнуурын Холбооны зарим үйл ажиллагааны талаар саналаа албан ёсоор явууллаа.

17. Нийгэмлэгийн удирдах зөвлөлөөр тулгамдсан асуудал хэтийн байдлын асуудлуудыг хамтын шийдвэр гаргаж ажиллав.

18. ММСГН-ийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь Улсын Бүртгэлийн газарт өгч тайлагнасан.

19. Нийгэмлэг өөрийн санхүүгийн тайлан, татварын тайлан, нийгмийн даатгалын тайланг улирал, сар бүрээр гаргаж тооцоогоо хийж байна

20. Удирдах зөвлөлийн дарга Ж.ТүмэнАюуш /99117159/ ХУД 11-р хороо 2-р хэсэг Лагшири зaisan виллаж 5-р байр 5 тоот, Гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн /99114360/ БГД 6-р хороо 10-р хороолол ХД- 58 байр 01 тоот, Нийгэмлэгийн ажилтан Н.Ганхуяг/96961096/ ЧД. 3-р хороо 23-р байр 9 тоот.

Гишүүн Б.Зулбаяр/99109486/ ЧД 5-р хороо. 6-р хороолол. 9-54, С.Батсайхан/99170944/ БГД. 12-р хороо 4-р хороолол 20- 144, Ганзориг/99022468/, ЧАНХАА/99008163/.

Хоёр. Нийгэмлэгийн ажилд оршиж буй дутагдал доголдол.

1. Азийн Гагнуурын Холбооны гагнуурчдаас шалгалт авч мэргшүүлэх тогтолцоог Монголд нэвтрүүлэх чиглэлд тодорхой ахиц гарсангүй. Энэ нь өнөөдөр Монголд үйлчилж буй хууль эрх

зүйн орчин болон төр засгийн бодлогтой холбоотой хэдий ч нийгэмлэгийн зүгээс идэвхи чармайлт сул байсан.

2. Гишүүнчлэлээ өргөтгөх тал дээр хангалтгүй ажиллав
3. Материал судалын чиглэлээр тодорхой ажлууд хийгдээгүй
4. Нийгэмлэгийн зүгээс гишүүн байгууллагуудыг гагнуурын техникийн дэвшил сүүлийн үеийн ололт амжилтын мэдээллээр хангах ажил сул байв

Гурав. Нийгэмлэгийн зүгээс цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар.

ММСГН ийн зүгээс гагнуурын ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх боловсронгуй болгох зорилгоор дараах ажлуудыг 2018 онд хийхээр төлөвлөж байна

1. ММСГН ийн үйл ажиллагааг байгууллагуудад сурталчлах гишүүнчлэлийн эгнээгээ өргөтгөх
2. МСҮТөвүүдийн шинэ залуу гагнуурын багш наарт гагнуурын сургалт хичээл зохион байгуулах
3. Гишүүн байгууллагуудын гагнуурын инженерүүдэд сургалт семинар зохион байгуулах
4. Мэргэшлийн гагнуурчид болон гагнуурын мэргэжлийн инженер техникийн ажилтныг мэргэшүүлж эрх олгох ажлыг дүрмийн дагуу зохион байгуулж ажиллах гагнуурчдын улсын хэмжээний бүртгэлийг шинэчлэх
5. БНХАУ-ын Бээжиннд болох олон улсын гагнуурчдын ур чадварын „ARC CUP- 2018” тэмцээнд Монголын багийт бэлдэж оролцуулах
6. ММСГН-ийн боловсон хүчнийг бэхжүүлэх арга хэмжээ авах
7. 2019 онд Казаньд болох дэлхийн ур чадварын тэмцээнд оролцох Монголыг оролцогчийг тодруулах,, Монгол ур чадвар- 2018” тэмцээний 1,2- р шатлалыг зохион байгуулах.
8. Гагнуурын олон улсын үзэсгэлэн семинарт гишүүн байгууллага мэргэжлийн хүмүүсийг оролцуулах ажлыг зохион байгуулах
9. АГХ-ы хурал үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
10. Нийгэмлэгийн танилцуулга шинээр хийх вебсайтыг тогтмол ажиллуулах зэргээр сурталчилгааны ажлыг идэвхжүүлэх

Тайлан бичсэн / Н.Мягмарсүрэн/

ММСГН ийн гүйцэтгэх захирал